



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 16 өдөр

Дугаар A/221

Улаанбаатар хот

**Засаг даргын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний
биелэлтийг үнэлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны A/19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцээд жилийн эцсийн байдлаар 90,7 хувийн хэрэгжилттэй, “Үр дүнтэй” гэж үнэлсүгэй.

2.Багахангай дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ